



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/617

Арвайхээр

Буцалтгүй тусламж олгох тухай

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, аймгийн Засаг даргын 2018 оны а/676 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн Засаг даргаас нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж үзүүлэх журам”-ын 2.1, 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Гэр бүл, хүний хөгжлийн төвийн захирал асан Ж.Энхтуяа нь өвчний учир нас барсан тул түүний ар гэрийхэнд 300000 (гурван зуун мянга), аймгийн Засаг даргад хандаж мөнгөн тусламж хүсч өргөдөл ирүүлсэн хүнд өвчтэй, өөрийн орлогогүй, өрх толгойлсон хавсралтад дурьдсан нэр бүхий 4 иргэнд 1150000 (нэг сая нэг зуун тавин мянга) төгрөгийн нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж олгосугай.

2. Дээрх зардал болох 1450000 (нэг сая дөрвөн зуун тавин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101143

Аймгийн Засаг даргын 2019 оны 10  
дугаар сарын 03-ны өдрийн 1074 дугаар  
захирамжийн хавсралт



НЭГ УДААГИЙН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ ОЛГОХ  
ИРГЭДИЙН НЭРС

№	Овог, нэр	Оршин суугаа хаяг	Мөнгөн дүн
1.	Ц.Баатар	Нарийнтээл сумын иргэн	500000
2.	Ч.Шоовдор	Арвайхээр сумын иргэн	300000
3.	Н.Цэвэлмаа	Арвайхээр сумын 4 дүгээр багийн иргэн	300000
4.	Л.Наранцэцэг	Арвайхээр сумын иргэн	50000
<b>Нийт дүн</b>			<b>1150000</b>

-oOo-